

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР
ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 17 (ТОЙМ)**

Хуралдаан 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 14.50 цагт эхэлж, 16.30 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 40 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ-үнэлгээний газрын дарга болон Засгийн газрын агентлаг Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газар, Эрчим хүчний газар, Газрын тосны газрын дэд дарга нарын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай	Батжаргалын Заяабалыг Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ-үнэлгээний газрын даргын; Хорлоогийн Гэрэлчулууныг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын дэд даргын; Бульданы Эрдэнэбилэгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын дэд даргын; Пүрэвжавын Ганхүүг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрчим хүчний газрын дэд даргын албан тушаалд тус тус томилуулахаар нэр дэвшүүлэн томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
2	Зарим агентлагийн даргын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийн тухай	1.Монгол Улсын Засгийн газрын агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Стандартчилал, хэмжил зүйн газар, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын албан тушаалууд (ажлын байр)-ын тодорхойлолтын үйл ажиллагааны чиг үүрэгт зарим өөрчлөлт орсон байх тул эдгээр агентлагийн дарга нарын ажлын байранд Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулах нь зүйтэй гэж үзэх. 2.Дээр дурдсан агентлагуудын дарга нарын ажлын байрны тодорхойлолт, захиалгыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж ирүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт зөвлөх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов
3	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалттай холбогдуулан гаргасан О.Ганбат нарын гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	Нийслэлийн Мал, эмнэлгийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн шинээр зохион байгуулж явуулахыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд үүрэг болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
4	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Ахлах сургуулийн захирлын сонгон шалгаруулалтын талаар тус сумын Засаг дарга н.Манкейгийн гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	“Дүгнэлтийн тухай” Баян-Өлгий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2009 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоол хууль зөрчөөгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж

		үзэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол.
5	Төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал зэрэглэлд хамааран ажиллаж байсан зарим хүмүүсийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>1.Долоонжингийн Идэвхтэн (2004-2008 онд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дарга);</p> <p>2.Балдангийн Энхмандах (2006-2008 онд Байгаль орчны болон Гадаад харилцааны дэд сайд);</p> <p>3.Лувсанцэрэнгийн Оргил (2008-2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх);</p> <p>4.Цэдэнжавын Сүхбаатар (2004-2006 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, 2009 оны 6 дугаар сараас Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх);</p> <p>5.Кадырын Сайраан (2004-2008 онд Улсын Их Хурлын гишүүн, 2008 оноос Ерөнхий сайдын зөвлөх);</p> <p>6.Цэрэндоржийн Ганхуяг (1996-2000 онд Улсын Их Хурлын гишүүн, 2004-2008 онд Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд, сайд);</p> <p>7.Данзандаржаагийн Туяа (2001-2008 онд Улсын Их хурлын гишүүн);</p> <p>8.Доржванчигийн Чагнаадорж (1998-2000 онд Орхон аймгийн Засаг дарга);</p> <p>9.Должингийн Нэргүй (2005-2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон нутгийн хөгжлийн бодлогын зөвлөх);</p> <p>10.Самдангийн Цэдэндамба (2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлогын зөвлөх) нарыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Улсын мэргэжлийн хяналтын газрын Хилийн мэргэжлийн хяналтын албаны эм био бэлдмэлийн чанарын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшигч Д.Хишигсүрэн, Мал эмнэлгийн хяналтын албаны улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшигч Д.Доржсүрэн нарын гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн Тухай	<p>1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 372 тоот тушаалын “Д.Туяацэцэгийг Хилийн мэргэжлийн хяналтын улсын албаны эм, био бэлдмэлийн чанарын хяналтын улсын байцаагчийн, Г.Элдэв-Очирыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд тус тус томилсон хэсгийг хүчингүй болгох.</p> <p>2.Мэргэшлийн шалгалтад дээрх албан тушаалын сул орон тоонд өрсөлдөн хамгийн өндөр оноо авч, Төрийн албаны зөвлөлөөс томилуулахаар нэр дэвшүүлсэн Д.Хишигсүрэнг Хилийн мэргэжлийн хяналтын улсын албаны эм, био бэлдмэлийн чанарын хяналтын улсын байцаагчийн, Д.Доржсүрэнг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд 2009 оны 7 дугаар сарын 30-ны дотор томилж, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн “Төрийн жинхэнэ албанд нэр дэвшүүлэх тухай” 100 дугаар тогтоолыг биелүүлэхийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ц.Шийрэвдамбад үүрэг болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав.</p>
7	Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан С.Оюунтуяагийн гаргасан	1.Б.Оюунтуяаг “Албан тушаалаас чөлөөлөх тухай” Нийслэлийн Татварын газрын даргын

	гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	2009 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 42 дугаар тушаал, Д.Энхбатыг “Албан тушаалд томилох тухай” Нийслэлийн Татварын газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 44 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцох. 2.Б.Оюунтуяаг Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргын албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулахыг Нийслэлийн Татварын газрын дарга С.Энхбаатарт үүрэг болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав.
8	Төрийн зарим байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	1/Содомбалжирын Ихбаярыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын “Нийгмийн хамгааллын хэтийн тооцоолол, загварчлал”-ын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд; 2/Жаргалсайханы Ууганбатыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хамтын ажиллагааны хэлтсийн “Гадаад харилцаа”-ны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд; 3/Намсрайн Наранцогтыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын “Төрийн нарийн бичгийн даргын туслах”-ын албан тушаалд; 4/Баасанхүүгийн Дуннаранг мөн яамны Хууль зүйн бодлогын газрын “Төрийн байгууламж, захиргааны чиглэлийн хууль тогтоомж” хариуцсан мэргэжилтний албан тушаалд; 5/Шараагийн Шижирбатыг Эрчим хүчний газрын Судалгаа, мэдээлэл үнэлгээний хэлтсийн “Эрчим хүчний зураг төсөл, техникийн хяналт”-ын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд; 6/Баасанхүүгийн Баясгаланбаатарыг Эрчим хүчний газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн “Усны эрчим хүч”-ний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд; 7/Төмөртотоогийн Ундрахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын “Дотоод ажил” хариуцсан мэргэжилтний албан тушаалд тус тус томилуулахаар нэр дэвшүүлж, томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
